

**МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙДЫН
ТУШААЛ**

2018 оны ... сар ... өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Тушаалд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.9, 17.1.10 дахь заалт болон Сангийн яамны дотоод аудитын хорооны 2017 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 01 дугаартай тогтоолыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Сангийн сайдын 2016 оны “Журам шинэчлэн батлах тухай” 82 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын “Монгол Улсын мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох шалгалтын журам”-д дараахь нэмэлт, өөрчлөлтийг оруулсугай. Үүнд:

1. а/ Журмын “Нэг. Нийтлэг үндэслэл” гэсэн хэсгийн 1.3-г “Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх заалтын дагуу мэргэшсэн нягтлан бодогчийн эрхийг хугацаагүй олгоход энэхүү журмын холбогдох заалтыг баримтална.” гэснийг “Институт нь мэргэшсэн нягтлан бодогчийн эрхийг хугацаагүй олгохдоо энэхүү журмын холбогдох заалтыг баримтална.” гэж;
- б/ Журмын “3 дугаар зүйл. Мэргэшсэн нягтлан бодогчийн шалгалтыг зохион байгуулах” гэсэн зүйлийн 3.7-г “..аймаг орон нутгийн харьяалалтай хүн хүсвэл Улаанбаатар хот болон бусад аймагт шалгалт өгч болно.” гэснийг “аймаг орон нутгийн харьяалалтай хүн хүсвэл Улаанбаатар хот болон бусад аймагт шалгалт өгч болох бөгөөд 6 сарын хугацаанд шалгалт тус бүрийг өөр аймагт дахин өгөхийг хориглоно.” гэж;
- в/ Журмын “4 дүгээр зүйл. Шалгалтыг зохион байгуулах комиссын эрх, үүрэг” гэсэн зүйлийн 4.1 “..комиссын бүрэлдэхүүнийг Сангийн сайдын тушаалаар жил бүрийн эхэнд томилно.” гэснийг “... комиссын бүрэлдэхүүнийг Сангийн сайдын тушаалаар жил бүрийн 4 дүгээр сарын 1-ний өдрийн дотор томилно” гэж;
- г/ 4.4.2-г “...хяналтыг үр өгөөжтэй дэвшилтэт арга, хэлбэрээр зохион байгуулах” гэснийг “Шалгалтыг үр өгөөжтэй дэвшилтэт арга, хэлбэр болон туслах үүрэг бүхий бүрэлдхүүнтэйгээр зохион байгуулж, явцын хяналтыг тавих” гэж;
- д/ Журмын “5 дугаар зүйл. Шалгуулагчийн хүлээх үүрэг, хариуцлага” гэсэн зүйлийн 5.7-г “...мэхлэхийг оролдсон тохиолдолд тухайн шалгуулагчийн бүртгүүлсэн болон өгсөн бүх шалгалтыг хүчингүй болгоно.” гэснийг “.. мэхлэхийг оролдсон, шалгалтын явцад материал хуулах, зураг авах, гар утас ашиглан захидал /мессеж/ илгээх, авах, бусдад дамжуулсан тохиолдолд тухайн шалгуулагчийн бүртгүүлсэн болон өгсөн бүх шалгалтыг хүчингүй болгож дахин шалгалтад орох эрхийг шалгалтын комиссын шийдвэрээр 1 жил хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ.” гэж;
- е/ Журмын “8 дугаар зүйл.Мэргэшсэн нягтлан бодогчийн хугацаагүй эрх олгох шалгалт, шалгалтын үнэлгээ” гэсэн хэсгийн 8.5-г “.... ажилладаг байгууллага нь хариуцаж болно.” гэснийг “.. ажилладаг байгууллага нь хариуцна.” гэж тус тус өөрчилсүгэй.

2. а/ Журмын “3 дугаар зүйл. Мэргэшсэн нягтлан бодогчийн шалгалтыг зохион байгуулах” гэсэн зүйлийн 3.9-т “ Шалгалтын материалыг институт 3 сарын турш хадгална.” гэж;

б/ Журмын “4 дүгээр зүйл.Шалгалтыг зохион байгуулах комиссын эрх, үүрэг” гэсэн зүйлийн 4.2¹-т “Шалгалтын комиссын бүрэлдэхүүнийг 2 жил тутамд 20-иос доошгүй хувийг нь шинэчлэн өөрчилнө.” гэж;

в/ 4.8-т “Шалгалтын комиссын нарийн бичгийн дарга нь саналын эрхгүй бөгөөд мэргэшсэн нягтлан бодогчийн шалгалтад оролцогчдыг бүртгэх, баталгаажуулах, шалгалтын дүнг нэгтгэх, мэдээлэх үүрэгтэй.” гэж;

г/ 4.9-т “Шалгалтын комиссын дарга, гишүүн, нарийн бичгийн дарга нь энэ журамд заасан эрхээ хэтрүүлэн хэрэглэх, үүргээ биелүүлэхгүй байх, шалгалтын тестийн нууцлалыг задруулсан бол комиссын аль нэг гишүүний санаачлагаар комиссын гишүүдийг зарлан хуралдуулж, тухайн гишүүнийг эргүүлэн татах олонхийн саналыг үндэслэн Сангийн сайдад өргөн мэдүүлнэ.” гэсэн заалтыг тус тус нэмсүгэй;

Хоёр. Энэ тушаалын хэрэгжилтэнд байнгын хяналт тавьж ажиллахыг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар /Ч.Чимидсүрэн/-т үүрэг болгосугай.

САЙД

Ч.ХҮРЭЛБААТАР